



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2019 оны 12 сарын 24 өдөр

Дугаар 644

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах  
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Гаалийн ерөнхий газрын харьяа Шивээхүрэн дэх гаалийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, сэргээн засварлах боломжгүй болсон нийт 1 ширхэг 2,600,000.00 (хоёр сая зургаан зуун мянга) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Наранцогт, Гаалийн ерөнхий газрын дарга Б.Асралт, Шивээхүрэн дэх гаалийн газрын дарга Өнөрбуян дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Акталсан хөрөнгийг худалдсанаас олох орлогыг (худалдахтай холбогдсон гарсан зардлыг хассан дүнгээр) улсын төсөвт төвлөрүүлэх;

2.5. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.


ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД

0001297



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын  
газрын 2019 оны 12 дугаар сарын 12-  
ны өдрийн 644 дугаар тогтоолын  
хавсралт

Гаалийн Ерөнхий газрын харьяа Шивээхүрэн дэх гаалийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй  
актлах үндсэн хөрөнгийн жагсаалт

| д/д | Хөрөнгийн нэр              | Ашиглал<br>тад орсон<br>он | Хэм<br>жих<br>нэгж | Тоо<br>хэм<br>жээ | Нэг бүрийн<br>үнэ<br>(төгрөгөөр) | Балансын дүн<br>(төгрөгөөр)                      | Хуримтлагдсан<br>элэгдэл (төгрөгөөр)          | Үлдэгдэл өртөг<br>(төгрөгөөр) |
|-----|----------------------------|----------------------------|--------------------|-------------------|----------------------------------|--------------------------------------------------|-----------------------------------------------|-------------------------------|
| 1   | Чиргүүлтэй мотор /пад пад/ | 12/31/2011                 | ш                  | 1                 | 2,600,000.00                     | 2,600,000.00                                     | 2,600,000.00                                  | 0.00                          |
|     | ДҮН                        |                            |                    | 1 (нэг)           |                                  | 2,600,000.00 (хоёр<br>сая зургаан зуун<br>мянга) | 2,600,000.00 (хоёр сая<br>зургаан зуун мянга) |                               |